

ХӨНГӨН БЕТОН ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ШИЙДВЭР

2024 оны 02 дугаар сарын 15-ны өдөр

№ 01

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59, 60, 62 дугаар зүйлд заасныг үндэслэн
ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:


1. Хөнгөн бетон ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 03-р сарын 28-ны өдөр 10 цагт Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Эв нэгдлийн гудамж-62/1, өөрийн байранд зарлан хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг Нэгдүгээр хавсралтаар, хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчид мэдэгдэх өдөр, журам, хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр, хуралд бэлтгэх явцад хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг Хоёрдугаар хавсралтаар баталсугай.
3. Хөнгөн бетон ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны ээлжит хурлаар шийдвэрлэх асуудлаар өгөх “Саналын хуудасны загвар”-ыг Гуравдугаар хавсралтаар баталсугай.
4. Хөнгөн бетон ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчид өгөх “Саналын хуудасны загвар”-ыг Дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.
5. Саналын хуудсаар санал авах сүүлийн өдрийг 2024 оны 3-р сарын 28-ны өдрөөр тогтоосугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг удирдах хурлын даргаар Б.Наранзулыг томилсугай.
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссыг доор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.
Дарга Г.Ганзориг
Гишүүд Б.Алтанцэцэг
Б.Батбаяр
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай шийдвэрийг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид хүргүүлэх, хурлын зар мэдээг Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”-д заасны дагуу хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх арга хэмжээ авахыг А.Чанцалдуламд даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Б.НАРАНЗУЛ

Гүйцэтгэх захирлын 2024 оны 02-р сарын 15-ны өдрийн
01 тоот шийдвэрийн Хавсралт-1



“Хөнгөн бетон” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн
2024 оны ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт

№	Хэлэлцэх асуудал	Танилцуулах хүн	Хугацаа
1	Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи дүгнэлтийг хэлэлцэж батлах	Б.Наранзул	30 минут
2	Ногдол ашиг хуваарилахгүй талаар танилцуулах	Б.Наранзул	5 минут
3	Төлөөлөн удирдах зөвлөлийг томилох тухай	Б.Наранзул	20 минут
4	Хөнгөн бетон ХК-ийг ХХК болгон хэлбэр өөрчлөх талаар хэлэлцэх	Б.Наранзул	20 минут


Гүйцэтгэх захирлын 2024 оны 02-р сарын 15-ны өдрийн
01 тоот шийдвэрийн Хавсралт-2



“Хөнгөн бетон” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны ээлжит хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх өдөр, журам, бүртгэлийн өдөр, хуралд бэлтгэх явцад хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалт

1. Хөнгөн бетон ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны ээлжит хурал хуралдуулах зарыг Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12-р сарын 14-ний өдрийн 377 тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”-д заасны дагуу хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэнэ.
2. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр нь ээлжит хурал хуралдуулах зарыг нийтэд мэдээлсэн өдрөөс хойш 15 дахь өдөр буюу 2024 оны 03-р сарын 07-ны өдөр байна.
3. Хувьцаа эзэмшигчид нь ээлжит хурал зарласан үед дараахь бичиг баримттай танилцаж болно. Үүнд:
 - А). Компанийн 2023 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан
 - Б). ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчийн танилцуулга
 - Б). Компанийн хэлбэр өөрчлөх тухай /ХХК болгох/

Гүйцэтгэх захирлын 2024 оны 02-р сарын 15-ны
өдрийн 01 тоот шийдвэрийн Хавсралт-3



**“ХӨНГӨН БЕТОН” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН 2024 ОНЫ
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН САНАЛЫН ХУУДАС**

Компанийн оноосон нэр: Хөнгөн Бетон Хувьцаат Компани
Хурал хуралдах газар, өдөр, цаг: ХУД, 3-р хороо, Эв Нэгдлийн гудамж-62/1,
“Хөнгөн бетон” ХК-ийн оффисын байр,
2024 оны 03-р сарын 28-ны 10:00 цагт

Хувьцаа эзэмшигчийн овог: Нэр:

Хувьцааны төрөл: Энгийн

Эзэмшдэг хувьцааны тоо:


ТУЗ-ийн гишүүдийн сонгох арга: Кумулятив

Шийдвэрлэх асуудал ба санал өгөх хэлбэр

Д/ д	Шийдвэрлэх асуудал	Санал өгөх хэлбэр: /сонгосон саналыг + тэмдгээр тэмдэглэнэ/.		
		Зөвшөөрсөн	Татгалзсан	Түтгэлзсэн
1	Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи дүгнэлтийг хэлэлцэж батлах			
2	Ногдол ашиг хуваарилахгүй талаар			
3	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох	Кумулятив аргаар санал авах		
4	Хөнгөн бетон ХК-ийг ХХК болгон хэлбэр өөрчлөх талаар			

Санал өгсөн Хувьцаа эзэмшигч: /..... /

2024 оны 03-р сар 28-ны өдөр



**“ХӨНГӨН БЕТОН” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНИЙ
СОНГУУЛИЙН САНАЛЫН ХУУДАС**

Компанийн оноосон нэр: Хөнгөн Бетон Хувьцаат Компани
Хурал хуралдах газар, одор, цаг: ХУД, 3-р хороо, Эв Нэгдлийн гудамж-62/1,
“Хөнгөн бетон” ХК-ийн оффисын байр,
2024 оны 03-р сарын 28-ны 10:00 цагт

Хувьцаа эзэмшигчийн овог: Нэр:

Хувьцааны төрөл: Энгийн

Эзэмшдэг хувьцааны тоо:

ТУЗ-ийн гишүүдийн сонгох арга: Кумулятив

Нэг: Ердийн гишүүд

Д/д	ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчдийн нэрс	Кумулятив аргаар өгсөн саналын эрхийн тоо
1		
2		
3		
4		
5		
6		

Хоёр: Хараат бус гишүүд

Д/д	ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн нэрс	Кумулятив аргаар өгсөн саналын эрхийн тоо
1		
2		
3		

Санал өгсөн Хувьцаа эзэмшигч: /..... /

Тайлбар: Компанийн тухай хуулийн 72.1.3 дугаар зүйлд Кумулятив аргаар санал хураах, сонгох тохиолдолд Төлөөлөн удирдах зөвлөл болон Гүйцэтгэх удирдлагын гишүүнд нэр дэвшигч бүрд өгсөн саналын тооны нийлбэр нь тухайн хувьцаа эзэмшигчийн саналын эрхийн тооны нийт дүнгээс илүүгүй байх бөгөөд саналын эрхийн тооны нийт дүн нь тухайн хувьцаа эзэмшигчийн эзэмшиж байгаа саналын эрх бүхий энгийн хувьцааны тоог сонгогдох гишүүний тоогоор үржүүлсэнтэй тэнцүү байна.

2024 оны 03-р сар 28-ны өдөр